



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Наран СУМЫН
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

2024. 08. 08 № 450
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЭЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.ДАВАА

Наран сумын Монгол Ардын намын хорооны
Тэргүүлэгчдийн 2024 оны 6 дугаар 23-ний
өдрийн ...08... тоот тогтоолын хавсралт



СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Нэг.Хүний хөгжлийн бодлого

- 1.1.Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.
- 1.2.Орлого багатай өрхийн насанд хүрсэн ажил эрхлээгүй гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.3.Ажилгүй иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлттэй зээл хөтөлбөрт хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.4. Иргэдээ стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангана.
- 1.5.Инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны хороолол бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 1.6. Сумын эрүүл мэндийн төвийн боловсон хүчний тогтвор суурьшилтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлж орон нутгийн дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.7.Сумын хүн амыг эрт илрүүлгийн үзлэг оношлогоонд тогтмол хамруулах замаар иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг чанарыг сайжруулна.
- 1.8. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.9. Эрүүл шүд-Эрүүл хүүхэл” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн архаг /ангина/өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.10 Үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, “Монгол бичиг”-ээр хэвлэгддэг ном сонин, сэтгүүлийг нэмэгдүүлнэ. Сумаараа монгол бичигтэн болох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.11. Сувилагч асрагчаар суралцагсдыг нэмэгдүүлж, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагыг сувилагч, асрагчаар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.12. Сумын эмнэлгийг инженерийн төв шугам сүлжээнд холбож халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.13. Сумын түүх, соёлын дурсгалыг бүртгэлжүүлж биет болон биет бус өвийг эзэмшигчдийн үзэсгэлэнг гаргана.

1.14.“Чадварлаг багш”, “Сайн сурагч” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулна.

1.15. Гэнэтийн байгалийн гамшиг эрсдлийн үед ЕБС-ийн танхимын хичээл завсардалт, теле хичээлийн хэрэгжилтийн үнэлгээ хийж, сурагчдад боловсролын агуулгыг нөхөж олгох олон сонголтод хувилбар бүхий зайн сургалтын агуулгыг баяжуулж, түгээнэ.

1.16.Өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлж зорилтод бүлгийн өрхийн тоог 50 хувиар бууруулна.

1.17.Хүн амын бүлгүүд ялангуяа эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.

1.18.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлж сумын хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрөөх тоглоомын талбай, спорт урлагын заалны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.19. Сумын төвийн гудамж талбайг камертай болгох, замын уулзваруудыг гэрлэн дохиотой болгох ажлыг хэрэгжүүлнэ.

1.20. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийн ажлыг тогтомжуулна.

1.21. Залуучууд, залуу гэр бүлийг сумандаа сайхан амьдрах нөхцөлийг хангаж орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц барихыг дэмжинэ.

1.22. Хүүхэд, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1.23. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангах хүрээнд сумын төвийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг тэдэнд нээлттэй болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.24. Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгжийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.25. Сумын төвд төвлөрсөн халаалтын уурын зуухыг барьж ашиглалтанд оруулна.

1.26. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдсэн ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

1.27. Хүүхдийн номын сан, хүүхдэд зориулсан бүтээл зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх санал санаачлагыг дэмжиж ажиллана.

Хоёр. Эдийн засаг, ХАА-н бодлого

2.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгоно.

2.2. Сумын малын эмч нарыг бодлогоор дэмжиж малын халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулан гоц халдварт өвчингүй, тайван бүс болно.

2.3.Өрх бүр хүнсний ногоо тариалах боломжийг бүрдүүлж өрх бүрийг хүлэмжээр хангах бодлого барина.

2.4.Өлзийт булгийг дотоодын аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр тохижуулан ажиллуулна.

2.5. Сумын нутаг дэвсгэр дэх булаг шандын эхийг хамгаалах ажлыг хийнэ.

2.6. Сумандаа мод үржүүлгийн газар бий болгох замаар сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.7. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

2.8. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.9. Шинэ хоршоо хөдөлгөөнийг дэмжиж иргэдийг олноор хамруулж ажлыг идэвхижүүлнэ.

2.10. Суманд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана.

Гурав. Засаглалын бодлого

3.1. Сумын төр захиргааны бүхий үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.

3.2. Хүнд сургалтгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж төсвийн зардлыг хэмнэнэ.

3.3. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл,хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг тогтолцоог бий болно.

3.4.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах,шаардлагатай техник хэрэгслэлээр хангана.

3.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл,ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

НАРАН СУМЫН МОНГОЛ АРДЫН

НАМЫН ХОРОО